



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A108

Улаанбаатар хот

**Коронавирус /КОВИД-19/ халдвараас
урьдчилан сэргийлэх
зарим арга хэмжээний тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн баталсан хуваарь, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс ирүүлсэн 2021 оны 04/394 тоот албан бичгийн дагуу Шинэ төрлийн Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний хүрээнд Худалдаа үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдийг QR кодоор бүртгэлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байдалд хяналт тавьж ажиллах ажилтнуудын нэрс, хуваарийг нэгдүгээр хавсралтаар, ажилтнуудын ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг хоёрдугаар хавсралтаар, шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Худалдаа үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдийг QR кодоор бүртгэлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байдалд хяналт тавьж ажиллахдаа халдвар хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг чанд мөрдөж, тайлан мэдээг ахлагчдаа хүргүүлж ажиллахыг хяналт тавих ажилтнуудад, нэгдсэн тайлан мэдээг тухайн өдөр бүрийн 18 цагт дүүргийн онцгой комисс, институтийн дотоод ажил, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэнд хүргүүлж ажиллахыг хяналт тавих ажилтнуудын ахлагч (Э.Энхбаяр)-д, хяналт тавих ажилтнуудын нэгдсэн тайлан мэдээг хүлээн авч нэгтгэн, архивлан, тайлагнаж ажиллахыг дотоод ажил, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (Б.Тэнгэрцэцэг)-д, хяналт тавих ажилтнуудыг удирдлага, арга зүйгээр хангаж даалгавар өгч, биелэлтийг хангуулан байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулж, зааварчилгаа хүргүүлэн ажиллахыг Захиргаа, удирдлага санхүүгийн хэлтэс (Л.Эрдэнэбат)-т тус тус даалгасугай.

3. Хяналт тавьж ажиллахад шаардагдах 4 860 000 /дөрвөн сая найман зуун жаран мянган/ төгрөгийг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу Хот төлөвлөлт, судалгааны институтийн 2021 оны үйл ажиллагааны бусад зардлаас бодож олгохыг нягтлан бодогч (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүү менежмент хариуцсан орлогч дарга (Б.Батсайхан)-д даалгасугай

ДАРГА



Ч.РЭГЗМАА

3150600017